



СЕКЮРИТИЗ
ҮЦК

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2020.08.17-2020.08.21



Энэхүү мэдээлэл нь Ард Секюритиз ҮЦК-аас зөвхөн мэдээллийн зорилгоор бэлтгэгдсэн болно. Өнгөрсөн үзүүлэлт нь ирээдүйн үр дүнгийн баталгаа болохгүй. Тиймээс та өөрт нийцсэн хөрөнгө оруулалт эсвэл арилжаа хийхдээ бие даан буюу өөрийн зөвлөхтэйгөө зөвшилцөж шийдвэр гаргах хэрэгтэй гэдгийг анхаарна уу!

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖААНЫ ТОЙМ

2020 оны 8-р сарын 17-21 хооронд

Монголын Хөрөнгийн Биржийн бүх мэдээллийг mse.mn-с авсан ба бусад мэдээллийн эх сурвалжийг дор бүр нь харуулсан болно.

Арилжааны товч мэдээ

Нийт арилжааны дүн(сая төгрөг)	721.2
Зах зээлийн үнэлгээ(сая төгрөг)	2,599,220.7
Хэлцлийн тоо	1,301
Арилжигдсан үнэт цаасны тоо	60

INDEX	Хаалт	Өөрчлөлт
TOP-20 INDEX	17,057.89	+0.91% ▲
MSE-A INDEX	8,315.25	+1.10% ▲
MSE-B INDEX	7,338.5	+0.45% ▲

Хамгийн өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Улсын Их Дэлгүүр	1,201.0	+33.44% ▲
Дархан Зочид Буудал	146.6	+14.98% ▲
Монгол Цахилгаан Холбоо	376.01	+14.33% ▲
Гермес Центр	130	+10.30% ▲
Стандарт Агрикалчер Групп	75	+10.29% ▲

Хамгийн уналттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Баянгол Зочид Буудал	25,020	-23.95% ▼
Монгол Савхи	550	-14.72% ▼
Женко Тур Брюо	76	-14.60% ▼
Нийслэл Өргөө	2,600	-13.33% ▼
Дархан Хөвөн	7,000	-12.50% ▼



Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компани	Төгрөг
Бидисек ҮЦК	614,991,250
Мирэ Эссет Секьюритис Монгол	210,308,089
Ард Секюритиз ҮЦК	121,738,631
Алекс Капитал ҮЦК	78,646,629
Гаули ҮЦК	73,584,247

Идэвхтэй арилжсан хувьцаа	Төгрөг
Женко Тур Брюо	250,267,859.00
Лэндмн ББСБ	131,249,858.60
АПУ	116,038,794.20
Эрдэнэ Ресурс Девело..	65,903,512.36
Ард Санхүүгийн Нэгдэл	45,222,457.00

Энэ долоо хоногт нийт 721.1 сая төгрөгийн арилжаа хийгдсэн ба нийт 1,301 хэлцэл хийгдэж 60 компанийн хувьцаа арилжаанд оролцсон байна.

Монголын Хөрөнгийн Биржийн Топ-20 индекс 17,058-д хүрч хаагдсан ба нийт зах зээлийн үнэлгээ 2.599 их наяд төгрөгийн үнэлгээтэй боллоо.

Улсын Их Дэлгүүр хувьцаат компанийн хувьцаа 1,201 хүрч энэ долоо хоногт 33.44% өсөж хаагдлаа. Харин Баянгол Зочид Буудал хувьцаат компанийн хувьцаа 25,020 хүрч энэ долоо хоногт -23.95%-р буурч хаагдлаа



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2020 оны 8-р сарын 17-21 хооронд

Монголын Хөрөнгийн Биржийн бүх мэдээллийг mse.mn-с авсан ба бусад мэдээллийн эх сурвалжийг дор бүр нь харуулсан болно.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД НЬ ХАМГИЙН ӨНДӨР ХУВИАР ӨССӨН ТОП-10 ХУВЬЦААТ КОМПАНИ

ҮЦТХТ-ийн судалгаанаас харвал 2018 оноос хойш хугацаанд хөрөнгийн зах зээлд оролцож, шинээр хөрөнгө оруулагч болсон хөрөнгө оруулагчдын тоо 11,000 гаруйгаар нэмэгдсэн дүн мэдээлэл байгаа.

Үүнээс Сүү /MSE:SUU/-д хөрөнгө оруулж, хувьцааг нь худалдан авсан иргэд, хөрөнгө оруулагчдын тоо хамгийн өндөр хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба тус компанийн хувьцаа эзэмшигчдийн тоо өнгөрөгч 7 хоногт 3,000 -д хүрчээ.marketinfo.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД НЬ ХАМГИЙН ӨНДӨР ХУВИАР ӨССӨН ТОП-10

Энэхүү үзүүлэлт нь 2018.12.31-нээс 2020.08.14-ний /20 сар/ өдрийн хоорондох өсөлтийн хувь хэмжээ юм

	Өсөлтийн %
Сүү /MSE:SUU/	82.4%
Мандал даатгал /MSE:MNDL/	61.5%
Хөвсгөл алтандуулга /MSE:ADU/	57.4%
Ард даатгал /MSE:AIC/	18.1%
Лэндмн ББСБ /MSE:LEND/	15.5%
Мик холдинг /MSE:MIK/	15.4%
АПУ /MSE:APU/	13.8%
Жуулчин дюти фрий /MSE:SUL/	12.8%
Айтүүлс /MSE:ITLS/	11.7%
Монгол шуудан /MSE:MNP/	8.6%

Илүү ихийг data.marketinfo.mn-ээс

www.marketinfo.mn

ЖЕНКО ТУР БЮРО: ХУВЬЦААНЫ 3.3% НЬ АРИЛЖИГДЛАА

Энэ 8-р сар гарснаас хойш Женко тур бюро /MSE:JTB/-ийн хувьцаанд 2 дах удаагаа Block trade явлаа.

Өнөөдөр гэхэд тус компанийн 2,631,582 ширхэг хувьцаа нэг бүр нь 95₮-ийн ханш дээр нийт 250.0 сая төгрөгөөр зарагдсан байна. Энэ нь тус компанийн нийт хувьцааны 3.3%-тай тэнцэж байгаа юм.

Үүнээс өмнө энэ сарын 12-ны өдөр мөн томоохон арилжаа явагдсаныг бид мэдээлж байсан билээ.marketinfo.mn

М-СИ-ЭС ГРУПП НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛНО

М-Си-Эс Групп нь олон улсад тэргүүлэгч хөрөнгө оруулалтын сан болох Cerberus Capital Management /Серберус/ компанитай хэлэлцээр хийж дууссанаа зарлав.

Энэхүү хэлцэлийн дүнд 1992 онд байгуулагдсан 45 тэрбум ам.долларын хөрөнгийг удирдан зохицуулдаг Серберус компани нь М-Си-Эс Группийн харилцаа холбоо болон өргөн хэрэглээний барааны салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 7 компанийн 20 орчим хувийг Серберус компани эзэмшихээр болж байгаа аж.

Тус группийн Захирлуудын зөвлөлийн дарга Ж.Оджаргал хэлэхдээ, "Энэхүү гэрээг байгуулснаар М-Си-Эс Групп зарим бизнесээ нэгтгэн олон улсад болон дотооддоо нээлттэй хувьцаат компани болгох эхлэл тавигдаж байна" гэж онцолжээ.marketinfo.mn

"ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ" -ЭЭС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) нь Хөндий Алтны дүүрэг дахь тусгай зөвшөөрлийн талбайд томоохон өрөмдлөгийн хөтөлбөр эхлүүлээ.

"Баян Хөндийд хийгдэж эхэлсэн энэхүү хөтөлбөрөөр нийт 18,000 метр өрөмдлөгийг он дуусахаас өмнө гүйцэтгэхээр төлөвлөсөн бөгөөд ирэх долоо хоногоос Хар Морь талбайд хоёрдугаар өрөмдлөгийн багыг ажиллуулж эхлэхээр болсон байна. Энэхүү хөтөлбөр нь дүүргийн шинэ талбайнуудыг шалгах, одоогийн ордуудтай зэрэгцээ орших талбайд нөөц нэмэгдүүлэх, одоогийн нөөцийн талбайг бататгах, цаашид Баян Хөндийн үйлдвэрлэлийн нөөцийг нэмэгдүүлэх зорилго тавиад байна.mse.mn